

**ДААЛГАВАР 1 : БИЕИЙН ХӨГЖЛИЙН ДАСГАЛ ХИЙЛГЭХ /ХУВИЛБАР А/**

**Зорилго:** 5-6 настай хүүхдийн бие бялдрын хувьд эзэмшсэн байвал зохих чадварууд болох хавсарсан хөдөлгөөн хийх эвсэл, авхаалж самбаа, тэнцвэр, уртын харайлт болон гүйх, үсрэх хөдөлгөөний гүйцэтгэлийг цогц байдлаар сориход оршино.

№	Хөдөлгөөний төрөл	Шалгах чадвар	Шалгуур үзүүлэлт
1	Үнэг дуурайж гүйх /2м/	Хавсарсан хөдөлгөөн хийх эвсэл	Үнэгний сүүл хошууг 2 гараар тодорхой илэрхийлэнгээ 2м гүйж чадсан бол
			Амьтан дуураингаа гүйх эвээ олохгүй бол
2	Хөлийн мөрийн дагуу чиглэл өөрчилж үсрэх /3 үсрэлт/	Авхаалж самбаа болон тэнцвэр	3 мөр алдаагүй тэнцвэртэй үсэрсэн бол
			1-2 мөр алдаагүй үсэрсэн бол
			Үсрэх явцад тэнцвэрээ алдсан бол
3	Байрнаас уртын харайлт хийх /80 см дотор/	Харайх чадвар	Хоёр хөлөөс зэрэг түлхээд хоёр хөлөөр зэрэг буухдаа 80 см харайсан бол
			Хоёр хөлөөс зэрэг түлхээд хоёр хөлөөр зэрэг буухдаа 70 см харайсан бол
			Хоёр хөлөөс зэрэг түлхээд хоёр хөлөөр зэрэг бууж чадаагүй, эсхүл 70см-ээс бага зайд үсэрсэн бол


**ДААЛГАВАР 2: АНХААРАЛ ТӨВЛӨРӨЛ, АЖИГЛАХ ЧАДВАР**

**Зорилго:** 5-6 настай анхаарал төвлөрөл, ажиглах чадварыг тодруулахад оршино.

**Даалгаврын асуулт:** Энэ зургийг анхааралтай ажиглаад, зургийг бүтэн болгоход тохирох хэсгийг олж заагаарай.


**"А" ХУВИЛБАР**

1




A B C

2




A B C

3




A B C

4



A B C

5



A B C

### **ДААЛГАВАР 3: БҮТЭЭЛЧ СЭТГЭЛГЭЭ**

#### Уг даалгавраар тодорхойлох төлөвшил, чадварууд:

- Бүтээх хандлага, бүтээх сэтгэлгээ
- Хувилбарт сэтгэлгээ
- Гүйлгээ ухаан
- Чөлөөт сэтгэлгээ
- Уян хатан сэтгэлгээ
- Сэтгэлгээний хурд
- Дасан зохицох чадвар
- Шинийг санаачлах чадвар
- Зориг
- Өөртөө итгэлтэй байдал
- Ажил, амьдралын туршлага гэх мэт

#### Ажлын заавар:

1. Тусгай хэрэглэгдэхүүн өгч, "Үүгээр өөр юу юу хийж болох вэ" гэсэн асуулт тавьж ярилцана.  
Жишээ нь: "Бал"
  - Энэ юу вэ?
  - Бал
  - Үүгээр юу хийдэг билээ?
  - Юм бичдэг.
  - Тэгвэл үүгээр бичихээс өөр юу юу хийж болох вэ?
  - Зурж болно.
  - Өөр?
  - .....
  - Өөр юу хийж болох вэ?
  - .....
  - Өөр?
  - ..... гэх мэтээр ярилцана.
2. Ярилцагч хүүхэд "Балаар нохой зурна, балаар уул зурна, балаар алим зурна" гэх зэргээр нэг төрлийн олон хувилбар хэлээд байвал багш "Зурахаас өөр юу хийж болох вэ" гэж чиглүүлнэ. Учир нь нэг төрлийн олон хариулт нь нэг л хариултад тооцогдоно.
3. Ярилцах явцдаа шалгагч багш ярилцагчийн хэлсэн санаа бүрийг үнэлгээний хуудасны "Ярилцагчийн гаргасан санаанууд" хэсэгт бичнэ.
4. Багш дөхүүлэх, сэдэлжүүлэх үг, санаа хэлэхийг хориглоно. Зөвхөн дээр дурдсан "Өөр", "Өөр юу хийж болох вэ?" гэсэн үгсээр дэмжлэг үзүүлнэ.
5. Хүүхдийг зоригжуулах, урамшуулах зорилгоор "Сайн байна", "Болж байна" гэх зэрэг аман үнэлгээ хэрэглэж болох боловч нэг хүүхдэд 2-оос дээш удаа хэрэглэхгүй байхыг хичээнэ.

**ДААЛГАВАР 4: СЭТГЭЛ ХӨДЛӨЛ**

1. Хүүхдийн зургийг хараад, энэ хүүхдийн сэтгэл хөдлөлийг багшдаа хэлж өгөөрэй.



2. Багш чинь Баяраа та хоёрт ижилхэн даалгавар өгчээ. Чи даалгавраа Баяраагаас илүү хийсэн боловч багш чинь Баярааг магтав. Чи юу гэж бодох вэ?
3. Чи юунаас айдаг вэ?
4. Ээж чинь гэрийн ажил ихтэй, завгүй байгаагаас болоод жоохон дүү чинь орон дээрээ уйлаад хэвтэж байлаа. Энэ үед чи яах вэ?
5. Төрсөн өдрийн баяраа тэмдэглэж байгаа гэр бүлийг хараад цонхны цаана зогсож байгаа охин юу гэж бодож байгаа бол?

